



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 4 дугаар сарын 18

Дугаар 4

Улаанбаатар хот

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН IV ХУРАЛДААН

Улсын онцгой комиссын хуралдаан 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 09.00 цагт Төрийн ордон дахь “Сүхбаатар танхим”-д 77 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Зудын эсрэг авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний талаар
*Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян*
2. Зүй бусаар хорогдсон малын сэг, зэм устгалын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
*Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга
А.Нарантуяа*
3. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Их Монгол, Дүнжингарав худалдааны төвийн авто замын уулзварт гарсан гал түймэрт өртсөн 207, 830 дугаартай барилга байгууламжид хийсэн Ажлын хэсгийн дүгнэлтийн талаар
*Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн дарга Ц.Баярбат*
4. “Дашваанжил” ХХК-д хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаарх Ажлын хэсгийн танилцуулга
*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын
хяналтын газрын дарга Б.Нарангараа*

5. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд гарсан ослын хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талаар

*Мөрдөн байцаах албаны дэд дарга,
цагдаагийн хурандаа Б.Батдэлгэр*

6. Улсын онцгой комиссын даргын 01 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хяналт шалгалтын талаарх танилцуулга

*Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга,
хурандаа Т.Баярхүү*

7. 'Гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төсөл'-ийн талаар

Үндэсний давхар даатгалын гүйцэтгэх захирал Б.Жавхлант

8. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатарт:

1.1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Их Монгол, Дүнжингарав худалдааны төвийн авто замын уулзварт болсон дэлбэрэлт, гал түймэрт өртсөн 207, 830 дугаартай барилга байгууламжийн хийц бүтээцийн бат бэх чанар, төлөв байдлыг тогтоох, лабораторийн туршилт, шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг үндэслэн Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 16 дугаар зүйл болон холбогдох бусад хууль, тогтоомжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үүнтэй холбогдон гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулах;

1.2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн гал түймэрт өртсөн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны 207 дугаар байрны оршин суугчдад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс хойш тодорхой хугацаанд түрээсийн төлбөр үргэлжлүүлэн олгох, үүнтэй холбогдон гарсан зардлыг хохирол учруулсан гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

1.3. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Их Монгол, Дүнжингарав худалдааны төвийн авто замын уулзварт гарсан гал түймэрт өртөж, нас барсан иргэдийн ар гэрт нэг удаагийн буцалтгүй тусламж олгох асуудлыг шийдвэрлэх;

Хоёр. Барилга, хот байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэнд:

2.1. БНБД 21-07-14 “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”-ын 5.8-дахь заалт буюу аюулгүйн зайн хэмжээсийг тэсэрч дэлбэрэх аюултай бодис ямар зайд, хэрхэн хор хөнөөл учруулж болзошгүй талаар шинжлэх ухааны үндэслэл, судалгаатай тооцоолол хийж, түүнд үндэслэн стандарт, норм, дүрэмд өөрчлөлт оруулах;

2.2. БНБД 21-07-14 “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”-ын 19.1 дэх заалтад өөрчлөлт оруулж, шатахуун түгээх станц болон автомашин хийгээр цэнэглэх станцыг тусдаа байхаар зохицуулж, хэрэгжилтийг хангуулах;

2.3. БНБД 21-07-14 “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”-ын 7-р хүснэгтэд шингэрүүлсэн нүүрс устөрөгчийн хийтэй бол орон сууц олон нийтийн барилга байгууламжаас 60 метр, БНБД 42-01-19 “Хийн хангамж” нормын 22-р хүснэгтэд ил савтай 10м.куб бол 18 метр гэж зөрүүтэй заагдсан хэмжээг өөрчлөх;

2.4. БНБД 42-01-19 “Хийн хангамжийн норм”-ын 8.124⁷/Хот суурин газар автомашин хийгээр цэнэглэх станцын савнуудын нийт багтаамж 10м³ -аас бага тохиолдолд газар дээр ил, түүнээс илүү бол газар доор байрлуулбал зохино/ дэх заалтыг өөрчилж “Хот суурин газрын автомашин хийгээр цэнэглэх станцын савыг багтаамж харгалзахгүй далд байрлуулах” гэж оруулах;

2.5. БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүй норм”-ыг аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах;

2.6. БНБД 30.01.04 “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” -ийн 6.39-д заасан хэсэг “Шатахуун түгээх станцын галын аюулгүйн норм БНБД 21-07-14-ийн 5-ийн хүснэгт 1-д заасан зай хэмжээтэй зөрчилдөж байгаа тул олон улсын жишигт нийцүүлэх;

2.7. Одоо мөрдөж буй норм дүрэмд тусгагдсан аюулгүйн зайн хэмжээс нь зөвхөн галын аюулгүй байдлыг хангахад мөрдөх зай хэмжээ бөгөөд иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн зай хэмжээг тодорхойлсон стандарт, норм, дүрэм шинээр боловсруулж мөрдүүлэх;

2.8. Дээр дурдсан норм, дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг 2024 оны 02 дугаар улиралд багтаан дуусгаж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Бямбацогтод:

3.1. “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2024 оны 02 дугаар улиралд багтаан батлуулж, хэрэгжилтийг хангах;

Дөрөв. Стандарт хэмжилзүйн газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн С.Батбаатар:

4.1. “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 4978:2017 улсын стандартад “Аюултай ачаа тээврийн хэрэгслүүдийг техникийн хяналтын үзлэгт жилд 2 удаа оруулах”, “Аюултай ачаа тээвэрлэлтэд ашиглах автотээврийн хэрэгслүүдийн насжилтыг тогтоох” гэсэн өөрчлөлтийг 2024 оны 02 дугаар улиралд багтаан оруулж, батлуулах;

Тав. Бүх шатны Засаг дарга нарт:

5.1. Шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн зайн хэмжээг зөрчиж газар олгохгүй байх, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, дүрэм зөрчиж газар олгосон, барилга, байгууламж, шатахуун түгээх станц барих зөвшөөрөл олгосон, ашиглалтад хүлээн авсан асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, хэрэгжилтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Улсын онцгой комисст танилцуулах;

5.2. Шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн зайн хэмжээ зөрчигдсөн барилга, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид зөвшөөрөл олгохгүй, зураг батлахгүй байх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

5.3. Шатахуун түгээх станцын ойр байрлалд сургууль, цэцэрлэг, хүүхдийн барилга байгууламж төлөвлөхдөө сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байр, хэвтэж эмчлүүлдэг эмчилгээний байгууллагуудын эдэлбэр газрын хил, орон сууц, олон нийтийн барилгын цонх (хаалга)/-оос галын аюулгүйн зай хэмжээг тогтоож өгөх; Тухайлбал:

хамгийн бага зайг сургууль цэцэрлэгийн барилгын хананаас биш “эдэлбэр газрын хил”-ээр тооцох;

5.4. Цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст тэсрэх багалын аюултай байгууламжийн барилгын зөвшөөрөл олгохгүй, төлөвлөхгүй байх;

5.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1.5-д “Барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа стандартад нийцсэн дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавих” гэсэн заалтын дагуу камерын хяналтыг цагдаагийн байгууллагын нэгдсэн санд холбох шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

5.6. Химийн хорт болон аюултай бодис, шатахуун, ахуйн болон үйлдвэрийн зориулалттай шатдаг хийг экспортлох, импортлох, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, зөвшөөрөл олгох, устгах явцад хяналт тавих ажлыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Зургаа. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзориг, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян нарт:

6.1. Химийн хорт болон аюултай бодис алдагдсан ослын үед хэмжих багаж, саармагжуулах бодис, үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хамгаалах хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон шаардлага хангасан орчин үеийн лаборатори байгуулах тооцоо судалгааг гаргаж, шаардагдах төсвийг 2024 оны 02 дугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулж, 2025 оны улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлүүлэх;

6.2. Химийн хорт болон аюултай бодис алдагдсан ослын үед үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг тогтмол сургах, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллах;

6.3. Химийн хорт болон аюултай бодис алдагдсан ослын үед үүрэг гүйцэтгэх үндэсний болон орон нутгийн чадавхийг нэмэгдүүлэх талаар санал боловсруулж, 2024 оны 02 дугаар улиралд багтаан Улсын онцгой комисс, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

Долоо. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энхбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Ганбаатар нарт:

7.1. Химийн хорт болон аюултай бодис, шатахуун, ахуйн болон үйлдвэрийн зориулалттай шатдаг хийг экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах явцад тавих

салбарын хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

Найм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Ганбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

8.1. Орон сууц, үйлчилгээ, олон нийтийн барилга, байгууламжид ашиглагдаж байгаа тэсэрч дэлбэрэх болон галын аюултай хийн хангамжийн ашиглалтын үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах, аюулгүй байдал, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, салбар хоорондын ажлын уялдаа холбоог хангах, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллах;

8.2. БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүй норм”-ыг Уул, Уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн А/274 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан жагсаалтаас хасах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Ес. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

9.1. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг, зэм устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж дуусгах, шаардлагатай хөрөнгийг батлагдсан төсвөөсөө гаргаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

9.2. Мал, амьтны сэг, зэм устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх орон нутгийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгүүдийг аймаг, сумдад томилж ажиллуулах;

Арав. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:

10.1. Мал, амьтны сэг зэм устгаж, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийхэд шаардлагатай ариутгалын зориулалттай автомашиныг зохих журмын дагуу улсын нөөцөөс гаргаж, шаардлагатай аймгуудад олгох;

10.2. Шаардлагатай тохиолдолд хандив тусламжаар цугласан хөрөнгийн тодорхой хувийг мал, амьтны сэг зэм устгах ажилд зарцуулах;

Арван нэг. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энхбаяр, Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Х.Лхагвасүрэн нарт:

11.1. Зудын улмаас хорогдсон мал, амьтны сэг сэм устгах, булшлах ажилд шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг дайчлан ажиллуулж, орон нутагт дэмжлэг үзүүлэх;

Арван хоёр. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нарт:

12.1. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах ажилд шаардлагатай орчин үеийн, хэмнэлттэй, олон улсад хэрэглэгддэг аргыг нэн даруй нэвтрүүлэх, түүнд шаардлагатай хөрөнгө санхүүгийн тооцоо судалгааг гаргаж, 2025 оны улсын болон орон нутгийн төсөвт суулгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

